



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 07 сарын 28 өдөр

Дугаар А/28

Сүхбаатар сум

Тусгай зөвшөөрөл олгох, сунгах,
хүчингүй болгох, түдгэлзүүлэх тухай

Монгол Улсын Зөвшөөрлийн тухай хуулийн 5.2 дугаар зүйл, 5.4 дүгээр зүйлийн 5.4.1 дэх, 5.5 дугаар зүйлийн 5.5.14 дэх, 5.5.15 дахь, 6.1 дүгээр зүйлийн 1.1 дэх, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1 дэх, 19 дүгээр зүйлийн 19.3.4 дэх, 19.14.3 дахь заалт, 19.17, 19.18 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон эрүүл мэндийн байгууллагыг нэгдүгээр, сунгасан эрүүл мэндийн байгууллагыг хоёрдугаар, үйл ажиллагаа эрхлэх эрх хүчингүй болгосон эрүүл мэндийн байгууллагыг гуравдугаар, түр түдгэлзүүлсэн эрүүл мэндийн байгууллагыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.


2. Алтанбулаг сумын Эрүүл мэндийн төвийн эмийн сан, Түнхэл, Бугант тосгоны Эрүүл мэндийн төвийн эмийн сангийн тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд тус тус бичилт хийж ажиллахыг тусгай зөвшөөрлийн комиссын нарийн бичгийн дарга /С.Эрдэнэтуяа/-д зөвшөөрсүгэй.

3. Дээрх аж ахуйн нэгж, байгууллагын дарга, холбогдох удирдлагуудад Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.16 дахь, 20 дугаар зүйлийн 20.2 дэх заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллахыг даалгасугай.

4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний хэлтсийн дарга /С.Азжаргал/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

У.ЭНХБАТ



Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 07 сарын 28-ны өдрийн А/28
дүгээр тушаалын 1 дүгээр хавсралт



Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа
эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байгууллага

Д/д	Байршил	Байгууллагын нэр	Тусгай зөвшөөрлийн чиглэл	Хугацаа
1	Мандал сум	Түнхэл тосгоны Эрүүл мэндийн төвийн эмийн сан	2-р зэрэглэлийн эмийн сан	3 жилээр
			Мансууруулах сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх	1 жилээр

Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 07 сарын 28-ны өдрийн *2128*
дүгээр тушаалын 2 дугаар хавсралт



Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа
эрхлэх тусгай зөвшөөрөл сунгасан байгууллага

Д/д	Байршил	Байгууллагын нэр	Тусгай зөвшөөрлийн чиглэл	Хугацаа
1	Ерөө сум	Бугант тосгоны Эрүүл мэндийн төвийн эмийн сан	2-р зэрэглэлийн эмийн сан	5 жилээр
2	Алтанбулаг сум	Эрүүл мэндийн төвийн эмийн сан	Мансууруулах сэтгэцэд нөлөөт эмээр үйлчлэх	1 жилээр

Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 07 сарын 28-ны өдрийн 1128
дүгээр тушаалын 3 дугаар хавсралт



Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай
Зөвшөөрлийг хүчингүй болгосон байгууллага

Д/д	Байршил	Байгууллагын нэр	Тусгай зөвшөөрлийн чиглэл	Хугацаа
1	Сүхбаатар сум	Мөнх ариун Сэлэнгэ ХХК-ийн Мөнх ариун Сэлэнгэ	Ахуйн шавж, мэрэгч устгах, халдваргүйжүүлэх үйлчилгээ	Хүчингүй болгосон

Эрүүл мэндийн газрын даргын
2025 оны 07 сарын 28-ны өдрийн 1128
дүгээр тушаалын 4 дүгээр хавсралт



Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа
эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон байгууллага

Д/д	Байршил	Байгууллагын нэр	Тусгай зөвшөөрлийн чиглэл	Хугацаа
1	Мандал сум	Элгэмсэг хараа ХХК-ийн Инээмсэглэл шүдний эмнэлэг	Шүдний эмнэлэг, согог засал	Түр түдгэлзүүлсэн